241

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр Дугаар А/42 Сүмбэр сум

Аймгийн Залуучуудын хөгжлийн
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтууд, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр"-ийн 5.2.8 дахь хэсэг, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний хөгжил, оролцоо, санал санаачилга, шинэлэг зан үйлийг дэмжих, эрхийг нь хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор Говьсүмбэр аймгийн Залуучуудын Хөгжлийн Зөвлөлийг газрын дэргэд байгуулсугай.

2. Аймгийн Залуучуудын Хөгжлийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн Залуучуудын Хөгжлийн Зөвлөлийн үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-д нийцүүлэн зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэн, үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б. Урангоо)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Г. Мөнхдэлгэр)-т даалгасугай.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ

D:/Бичиг хэрэг /тушаал

212

ГБХЗХгазрын даргын 2021 оны
05 сарын 28-ны өдрийн 01/42
дугаар тушаалын хавсралт

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ АЙМГИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТЭРГҮҮН:	Т.Ариунболор-Хувиараа бизнес эрхлэгч
ДЭД ТЭРГҮҮН:	Г.Гантулга-Хувиараа бизнес эрхлэгч
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	О.Оюун-Эрдэнэ- Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн мэргэжилтэн
ГИШҮҮД:	Б.Цагаандарь-Хувиараа бизнес эрхлэгч
	Т.Мөнхнаран- Хувиараа бизнес эрхлэгч
	Э.Ууганбаяр- Хувиараа бизнес эрхлэгч
	Н.Солонго- Байгаль, орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	А.Чулуунчимэг- Политехник коллежийн багш
	Э.Энхмаа- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2-р багийн иргэн
	М.Отгонбаяр- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн иргэн
	Б.Ганцолмон- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3-р багийн иргэн
	Б.Алтанцэцэг-Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 1-р багийн иргэн
	Д.Отгондаваа- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2-р багийн иргэн
	Н.Мөнхцэцэг-Баянтал сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш
	Б.Бодь-Эрдэнэ- Баянтал сумын 1-р багийн иргэн

D:/Бичиг хэрэг /тушаал